

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Говьсүмбэр аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ГСА-2022/12/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Чойрт хот
2022 он

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа
Утас:70543156 Цахим хаяг: Saranmuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр
Утас:70543179 Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Батсайхан
Утас: 70543179 Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Материаллаг байдал	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.6.1 Төсвийн төлөвлөлт	16
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	17
3.8 Аудитын гол асуудал	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт	18
4.1 Залруулсан алдаа.....	18
4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй.....	18
4.3 Албан шаардлага өгөгдөөгүй.....	18
4.4 Зөвлөмж	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ГСА	Говьсүмбэр аймаг
ТШЗ	Төсвийн шууд захирагч
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



**ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг
Утас/Факс: 976-7054 3179
И-мэйл: goviusumber@audit.gov.mn

2022.02.24 № 09

танай _____ -ны № _____ -г

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн "Прокурорын газар"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн "Прокурорын газар"-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

4208020027

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.САРАНТУЯА



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	6,784,220.00	29,206,082.00
33	АВЛАГА	0	1,087,496.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	0	887,496.00
33500	Бусад авлага	0	200,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0	200,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	6,784,220.00	28,118,586.00
35400	Хангамжийн материал	6,784,220.00	28,118,586.00
35420	Аж ахуйн материал	3,218,650.00	9,168,650.00
35470	Бусад хангамжийн материал	3,565,570.00	18,949,936.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	187,441,553.74	1,816,543,921.48
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	187,441,553.74	1,816,543,921.48
39200	Биет хөрөнгө	176,641,553.74	1,805,743,921.48
39201	Барилга, байгууламж, орон сууц	75,239,960.00	1,655,037,036.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-3,582,855.36	-5,600,866.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,300,000.00	67,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-20,208,333.30	-31,424,999.94
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	37,282,440.11	86,182,454.11
39206	Хуримтлагдсан элэгдэл	-7,598,334.47	-16,420,845.40
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	43,597,838.16	72,597,838.16
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,389,161.40	-21,926,695.07
39300	Биет бус хөрөнгө	10,800,000.00	10,800,000.00
39301	Программ хангамж	715,000.00	715,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-715,000.00	-715,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	10,800,000.00	10,800,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	194,225,773.74	1,845,750,003.48
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0	200,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0	200,000.00
41300	Өглөг	0	200,000.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0	200,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	194,225,773.74	1,845,550,003.48
51	Засгийн газрын хувь оролцоо	194,225,773.74	1,845,550,003.48
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	131,517,201.07	0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0	131,517,201.07
51200	Хуримтлагдсан үр дүн	27,494,925.15	1,678,819,154.89
51210	Өмнөх үеийн үр дүн	18,857,902.97	27,494,925.15

аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

51220	Тайлант үеийн үр дүн	8,637,022.18	1,651,324,229.74
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	35,213,647.52	35,213,647.52
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	194,225,773.74	1,845,750,003.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/ төгрөгөөр /	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	438,194,969.27	2,298,183,190.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,180,369.27	1,616,750,690.00
120	Нийтлэг татварын бус орлого	29,180,369.27	1,616,750,690.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	29,180,369.27	1,613,771,690.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	0	2,979,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	409,014,600.00	681,432,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	409,014,600.00	681,432,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	409,014,600.00	681,432,500.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	429,557,947.09	646,858,960.26
21	УРСГАЛ ЗАРДАЛ	429,557,947.09	646,858,960.26
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	425,392,094.09	637,336,600.12
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	304,441,986.00	427,188,629.86
210101	Үндсэн цалин	232,137,889.00	410,359,280.86
210102	Нэмэгдэл	64,613,440.00	16,829,349.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,690,657.00	0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,755,006.00	48,361,143.00
210201	Тэтгэврийн даатгал	26,745,080.00	34,157,791.72
210202	Тэтгэмжийн даатгал	3,011,429.00	2,939,601.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,331,863.00	2,460,112.11
210204	Ажилгүйдлийн даатгал	515,147.00	1,101,425.22
210205	Эрүүл мэндийн даатгал	5,151,487.00	7,702,212.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,735,505.00	39,275,645.00
210301	Гэрэл, цахилгаан	1,948,731.00	7,067,523.00
210302	Түлш, халаалт	4,985,744.00	27,285,122.00
210303	Цэвэр, бохир ус	981,030.00	2,718,000.00
210304	Байрны түрээс	8,820,000.00	2,205,000.00

аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	27,678,906.00	31,406,676.00
210401	Бичиг хэрэг	8,346,000.00	11,250,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,236,700.00	7,529,482.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,530,406.00	3,087,034.00
210404	Ном, хэвлэл	195,300.00	375,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,990,000.00	160,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,375,600.00	9,005,060.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	188,200.00	0
210408	Бараа материал акталсны зардал	7,816,700.00	0
2105	Нормативт зардал	65,000.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,516,400.00	16,829,460.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	105,000.00	1,472,000.00
210604	Урсгал засвар	3,411,400.00	15,357,460.00
2107	Томилолт, зочны зардал	1,409,300.00	2,400,000.00
210702	Дотоод албан томилолт	1,409,300.00	2,400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,719,229.00	16,355,224.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,062,537.00	15,070,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	694,300.00	845,260.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	173,600.00	146,964.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	231,000.00
210807	Газрын төлбөр	10,792.00	18,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28,070,762.09	55,519,822.26
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,700,000.00	8,034,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,487,500.00	18,891,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,883,262.09	28,594,722.26
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,165,853.00	9,522,360.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,515,000.00	2,000,000.00

аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,515,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,650,853.00	7,522,360.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,650,853.00	7,522,360.14
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	8,637,022.18	1,651,324,229.74
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	8,637,022.18	1,651,324,229.74

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	131,517,201.07	35,213,647.52	18,857,902.97	185,588,751.56
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	131,517,201.07	35,213,647.52	18,857,902.97	185,588,751.56
9	Тайлант үеийн үр дүн	0	0	8,637,022.18	8,637,022.18
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	131,517,201.07	35,213,647.52	27,494,925.15	194,225,773.74
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	131,517,201.07	35,213,647.52	27,494,925.15	194,225,773.74
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	131,517,201.07	35,213,647.52	27,494,925.15	194,225,773.74
19	Тайлант үеийн үр дүн	0	0	1,651,324,229.74	1,651,324,229.74
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	131,517,201.07	35,213,647.52	1,678,819,154.89	1,845,550,003.48

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	409,016,700.00	681,432,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,100.00	0
120	Нийтлэг татварын бус орлого	2,100.00	0
120009	Бусад орлого	2,100.00	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	409,014,600.00	681,432,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	409,014,600.00	681,432,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	409,014,600.00	681,432,500.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	401,878,270.00	637,507,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	401,878,270.00	637,507,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	397,712,417.00	627,984,739.86
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	303,615,097.00	424,138,957.00
210101	Үндсэн цалин	231,311,000.00	274,104,292.00
210102	Нэмэгдэл	64,613,440.00	131,355,137.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,690,657.00	18,679,528.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,579,510.00	52,298,311.86
210201	Тэтгэврийн даатгал	38,579,510.00	38,979,498.38
210202	Тэтгэмжийн даатгал	0	3,966,038.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	0	2,532,831.14
210204	Ажилгүйдлийн даатгал	0	563,675.97
210205	Эрүүл мэндийн даатгал	0	6,256,267.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,735,505.00	39,275,645.00
210301	Гэрэл, цахилгаан	1,859,565.00	7,067,523.00
210302	Түлш, халаалт	4,990,940.00	27,285,122.00
210303	Цэвэр, бохир ус	1,065,000.00	2,718,000.00
210304	Байрны түрээс	8,820,000.00	2,205,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,837,706.00	31,596,676.00
210401	Бичиг хэрэг	8,346,000.00	11,250,000.00
210402	Тээвэр, шатахуун	5,236,700.00	7,529,482.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,530,406.00	3,277,034.00
210404	Ном, хэвлэл	195,300.00	375,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,990,000.00	160,000.00

аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудиторын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,539,300.00	9,005,060.00
2105	Нормативт зардал	65,000.00	0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	65,000.00	0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	5,561,470.00	34,599,826.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	161,570.00	9,871,840.00
210604	Урсгал засвар	5,399,900.00	24,727,986.00
2107	Томилолт, зочны зардал	1,409,300.00	2,400,000.00
210702	Дотоод албан томиллолт	1,409,300.00	2,400,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,221,329.00	16,355,224.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,562,537.00	15,070,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	756,000.00	0
210803	Даатгалын үйлчилгээ	694,300.00	845,260.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	175,700.00	146,964.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилогоо	22,000.00	44,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0	231,000.00
210807	Газрын төлбөр	10,792.00	18,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,687,500.00	27,320,100.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,200,000.00	8,429,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,487,500.00	18,891,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,165,853.00	9,522,360.14
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,515,000.00	2,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,515,000.00	2,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,650,853.00	7,522,360.14
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,650,853.00	7,522,360.14
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	7,138,430.00	43,925,400.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	7,138,430.00	43,925,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	7,138,430.00	43,925,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	7,138,430.00	43,925,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	7,138,430.00	43,925,400.00

аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-7,138,430.00	-43,925,400.00
----	---	---------------	----------------

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

				/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	681,432,500.00	673,910,139.86	7,522,360.14
21	УРСГАЛ ЗАРДАЛ	681,432,500.00	673,910,139.86	7,522,360.14
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	679,432,500.00	671,910,139.86	7,522,360.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	430,298,100.00	424,138,957.00	6,159,143.00
210101	Үндсэн цалин	272,917,900.00	274,104,292.00	-1,186,392.00
210102	Нэмэгдэл	149,396,200.00	131,355,137.00	18,041,063.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,984,000.00	18,679,528.00	- 10,695,528.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	53,588,900.00	52,298,311.86	1,290,588.14
210201	Тэтгэврийн даатгал	37,503,200.00	38,979,498.38	-1,476,298.38
210202	Тэтгэмжийн даатгал	4,021,400.00	3,966,038.93	55,361.07
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,217,100.00	2,532,831.14	684,268.86
210204	Ажилгүйдлийн даатгал	804,300.00	563,675.97	240,624.03
210205	Эрүүл мэндийн даатгал	8,042,900.00	6,256,267.44	1,786,632.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	39,275,700.00	39,275,645.00	55.00
210301	Гэрэл, цахилгаан	7,577,400.00	7,067,523.00	509,877.00
210302	Түлш, халаалт	26,775,300.00	27,285,122.00	-509,822.00
210303	Цэвэр, бохир ус	2,718,000.00	2,718,000.00	0.00
210304	Байрны түрээс	2,205,000.00	2,205,000.00	0.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,596,700.00	31,596,676.00	24.00
210401	Бичиг хэрэг	10,387,500.00	11,250,000.00	-862,500.00
210402	Тээвэр, шатахуун	8,100,000.00	7,529,482.00	570,518.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,100,000.00	3,277,034.00	822,966.00
210404	Ном, хэвлэл	409,200.00	375,100.00	34,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,000,000.00	160,000.00	840,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,600,000.00	9,005,060.00	-1,405,060.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,526,000.00	78,525,226.00	774.00

аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210601	Багаж, техник, хэрэгсэл	20,000,000.00	19,999,740.00	260.00
210602	Тавилга	27,000,000.00	27,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	31,526,000.00	31,525,486.00	514.00
2107	Томилолт, зочны зардал	2,400,000.00	2,400,000.00	0.00
210702	Дотоод албан томилолт	2,400,000.00	2,400,000.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,426,100.00	16,355,224.00	70,876.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,070,000.00	15,070,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	845,300.00	845,260.00	40.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	217,800.00	146,964.00	70,836.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	44,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	231,000.00	231,000.00	0.00
210807	Газрын төлбөр	18,000.00	18,000.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,321,000.00	27,320,100.00	900.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,430,000.00	8,429,100.00	900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	18,891,000.00	18,891,000.00	0.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,000,000.00	2,000,000.00	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,000,000.00	2,000,000.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	2,000,000.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	681,432,500.00	673,910,139.86	7,522,360.14
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	681,432,500.00	673,910,139.86	7,522,360.14
310001	Улсын төсвөөс санхүүжих	681,432,500.00	673,910,139.86	7,522,360.14

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Говьсүмбэр аймгийн Прокурорын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд цахим төлбөрийн системд хяналт тавих талаар дотоод аудиттай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Батсайхан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2/111 дугаар албан бичгээр хуульд заасан хугацаанд ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөхийн 2021 оны 01 дүгээр сарын 19-ний А/04 тоот тушаалаар 2021 онд дараах зорилтуудыг дэвшүүлсэн байна. Үүнд:

1. Байгууллагын үйл ажиллагаанд шинэлэг арга барил, өнгө төрхийг нэвтрүүлэх
2. Хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын ажлын чанар үр дүнг сайжруулах
3. Мэдээлэл, технологийн ололт амжилтыг сургалтын болон суралцах арга барилд нэвтрүүлэх

Тайлант онд конторын барилгыг ашиглалтад оруулж, өнгө төрхийг сайжруулж, хашаа, цэцгийн мандал хийсэн.

Хэрэг бүртгэх мөрдөн байцаах ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах хэргийн шийдвэрлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор хяналтын ажлын үзүүлэлт бүрийг шалгуур үзүүлэлтээр сар бүр дүгнэн танилцан, цаашид авах арга хэмжээг тодорхойлж, “Хяналтын 5 хоног” буюу мөрдөгчөөс сар бүрийн 10-ны дотор хүлээн авсан гомдол мэдээлэл, хэргийг прокурорт танилцуулах, прокуророос 15-ны дотор даалгавар чиглэлээ өгч, 20-ны өдрийн дотор хяналтад ирүүлэн, 25-ын өдрийн эцэслэн шийдвэрлэхээр зохицуулалтын арга хэмжээ авч ажилласнаар хэрэгт тавих прокурорын хяналт сайжирч, гомдол мэдээллээс шууд эрүүгийн хэрэг үүсгэсэн тохиолдолд 4 дахин, мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт 2.1 хувиар өссөн үр дүн гарсан байна.

Прокурор ажилчдын зайнаас суралцах, сургалт явуулах нөхцөлийг сайжруулахаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүсэлт гарган цахим индэр, Шивээ-Овоо ХК-иар ухаалаг дэлгэцийг шийдвэрлүүлснээр сургалт зөвлөгөөн явуулах таатай орон зайг бүрдүүлж, сургалтуудыг зохион байгуулсан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар, түүний дотор дотоод аудитор нь тайлант онд тус газрын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Прокурорын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн зардлын 429,557.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 4,295.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3,436.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Аймгийн Прокурорын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,651,524.2 мянган төгрөгөөр буюу 850 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			0.0
Авлага		1,087.5	1,087.5
Урьдчилгаа			0.0
Бараа материал	6,784.2	28,118.6	21,334.4
Үндсэн хөрөнгө	187,441.6	1,816,543.9	1,629,102.4
Нийт хөрөнгө	194,225.8	1,845,750.0	1,651,524.2
Өр төлбөр	0.0	200.0	200.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	194,225.8	1,845,550.0	1,651,324.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	194,225.8	1,845,750.0	1,651,524.2

Авлага дансны үлдэгдэл 1,087.5 мянган төгрөг нь сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал олгосон 887.5 мянга, ажилчдад олгосон шагнал, урамшууллын зардлаас ХХОАТ-т 200.0 мянган төгрөгийг суутгаж, төсөвт төвлөрүүлээгүйгээс нийт 1,087.5 мянган төгрөгийн авлагыг үлдэгдлээр тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 28,118.6 мянган төгрөг болж 21,334.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд тус газрын барилга ашиглалтад орж аж ахуйн болон бусад хангамжийн материал худалдан авсан, Улсын Ерөнхий Прокурорын газраас үнэ төлбөргүй бараа материал хүлээн авсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6,784.2 мянган төгрөг байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 68,615.5 мянга, улсын Ерөнхий Прокурорын 2021.09.23-ны өдрийн А/120 дугаар тушаалаар 2,979.0 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авч, 71,594.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 50,260.1 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 28,118.6 мянган төгрөгийг үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд аж ахуйн материал 9,168.6 мянга, бусад хангамжийн материал 18,950.0 мянган төгрөг тус тус байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,892,632.3 мянган төгрөг болж 1,657,697.1 мянган төгрөгөөр өссөн нь конторын барилга шинээр ашиглалтад орсон, Улсын Ерөнхий Прокурорын газар болон аймгийн ИТХ-аас үнэ төлбөргүй хөрөнгө хүлээн авсан зэргээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 234,935.2 мянган төгрөг байснаас тайлант онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан 43,925.4 мянга, Улсын ерөнхий прокурорын 2021.09.23-ны өдрийн А/120 тоот тушаалаар 6,989.0 мянга, 2021.12.17-ны өдрийн А/181 тоот тушаалын нэгдүгээр хавсралтаар конторын барилга 1,572.999.5 мянга, гуравдугаар хавсралтаар 19,464.5 мянга, 4 дүгээр хавсралтаар 12,568.7 мянга, нийт 39,022.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, АИТХТ-ийн 2021.12.29-ний өдрийн А/217 дугаар тогтоолоор хурлын цахим индэр 1,750.0 мянга, нийт 1,657,697.1 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,892,632.3 мянган төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Биет бус хөрөнгөнд тайланд онд өөрчлөлт гараагүй байна.

Тайлант онд ажилчдад олгосон шагнал урамшууллаас ХХОАТ-т 200,0 мянган төгрөгийг суутган төсөвт төлөөгүйгээс өглөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,845,550.0 мянган төгрөг болж 1,651,324.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант хугацааны үр дүнгээр нэмэгдсэн байна.

Аймгийн Прокурорын газрын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 1,860,009.0 мянган төгрөгөөр буюу 424.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь санхүүжилтийн орлого 272,417.9 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн орлого 1,587,591.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн

Тайланд онд конторын барилга ашиглалтад орсон, үнэ төлбөргүй тоног төхөөрөмж хүлээн авсан зэргээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 317,301.0 мянган төгрөгөөр буюу 50.5 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардал нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамжийн бараа материалын зардал, бараа үйлчилгээний зардал тус тус байна.

Энэ нь тайлант онд конторын барилга ашиглалтад орсноор орон тоо нэмэгдсэнээс цалин болон НДШ-ийн зардал нэмэгдсэн, байр ашиглалтын тогтмол зардал өссөн, мэдээлэл, технологийн ололт амжилтыг сургалтын болон суралцах арга барилд нэвтрүүлэх зорилт дэвшүүлснээс хичээл үйлдвэрлэлийн зардал нэмэгдсэн зэрэг нь нөлөөлжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 491,896.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 491,896.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн ба төсвийн төслийг 55,765.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, 547,661.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Анх 547,661.4 мянган төгрөгийн төсөв батлагдсан боловч төсвийн тодотголоор цалин болон НДШ-ийн зардлыг 31,475.5 мянга, хангамж бараа материалын зардлыг 5,387.5 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 67,326.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 9,856.1 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 27,221.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 2,000.0 мянга, нийт 143,266.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, байр ашиглалтын тогтмол зардлыг 6,895.0 мянга, дотоод албан томилолтын зардлыг 2,600.0 мянга, нийт 9,495.0 мянган төгрөгөөр бууруулж, 681,432.5 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх “70703-Прокурорын хяналт” 1 хөтөлбөрийн хүрээнд 80801-үндсэн үйл ажиллагааны арга хэмжээг санхүүжүүлэхээр 672,862.5 мянга, 80802-ажил олгогчийн тэтгэмж урамшуулал арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,000.0 мянга, 82315-байцаан шийтгэх ажиллагаа арга хэмжээг санхүүжүүлэхээр 6,570.0 мянга, нийт 681,432.5 мянган төгрөгийн төсөв баталснаас 681,432.5 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 681,432.5 мянган төгрөгийн санхүүжилт авч 673,910.1 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагаанд зарцуулж, 7,522.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 673,910.1 мянган төгрөг буюу 98.9 хувьтай байгаа нь бүрэн орон тоогоор ажиллаагүйгээс цалин, НДШ-ийн зардлыг 7,451.6 мянга, тээврийн хэрэгслийн татварын зардлыг 70.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Санхүүгийн үр дүнгийн тайланд санхүүжилт 681,432.5 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материал, үндсэн хөрөнгийн орлого 1,616,750.6 мянга, нийт 2,298,183.1 мянган төгрөгийн санхүүжилт, орлогыг тайлагнасан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд санхүүжилт 681,432.5 мянган төгрөгийг тайлагнасан байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар тайлант онд гүйлгээ гараагүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Аудитаар Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108, А/111 дүгээр тушаалаар батлагдсан ерөнхий чиглэлд тусгагдсан асуудлыг онцлон үзсэн боловч зөрчил илрээгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Тухайн байгууллагад онцлох асуудал байхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.8-д заасан мэдээллийн давхардал, ач холбогдол үр нөлөөг харгалзан Шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Говьсүмбэр аймгийн “Прокурорын газар” нь 2021 онд нийт 168,323.9 мянган төгрөгийн 19 мэдээллийг байршуулахаас 70,251.5 мянган төгрөгийн 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд тус газарт Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендер зарлах хөрөнгө оруулалтын ажлын төсөв батлагдаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус газрын өмнөх оны санхүүгийн тайланд итгэл үзүүлсэн тул зөвлөмж өгөгдөөгүй болно.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аймгийн Прокурорын газрын үйл ажиллагаанд анхаарал татахуйц асуудал байхгүй байна

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,417.4 мянган төгрөгийн 4 алдаа зөрчил илэрснээс, 1,417.4 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, цахим төлбөрийн баримтад тавих хяналтыг сайжруулах алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын 1,417.4 мянган төгрөгийн 3 алдааг завсрын аудитаар залруулав. Үүнд:

1. Аж ахуйн материалын эхний үлдэгдлийг нярвын тайланд 330.0 мянган төгрөгөөр дутуу тусгасныг залруулав.
2. Ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 200.0 мянган төгрөгийн ХХОАТ-ыг суутгаж тооцоогүйг аудитын явцад авлага, өглөг үүсгэж залруулав.
3. Сахилгын шийтгэлтэй ажилчдад үр дүнгийн урамшуулал 887.4 мянган төгрөг олгосон тул аудитын явцад авлага үүсгэж залруулав.

4.2 Төлбөрийн акт тогтоогдоогүй

4.3 Албан шаардлага өгөгдөөгүй

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Татварын цахим бүртгэлийн системд худалдан авалтыг бүрэн шивэгдсэн эсэхэд хяналт тавьж ажиллаагүй, худалдан авалтын үнийн дүн зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.4, Сангийн сайдын 2017 оны 347-р тушаалаар батлагдсан журмын 6 дугаар зүйлийн 6.5, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан "ААНБ-ын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-д заасныг тус тус зөрчсөн байна.

1.2. Өгсөн зөвлөмж: Цахим төлбөрийн баримтад тавих дотоод хяналтыг сайжруулж, зөрчлийг давтан гаргахгүй байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Аймгийн Прокурорын газар	4	1,417.4	3	1,417.4	0	0	0	0	1	0